



БАЯНГОЛ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.07.30. № 037-2020/ОИ-НД-04
танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Баянгол сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Баянгол сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аudit MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аudit MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аudit MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.


Дүгнэлт

Баянгол сумын Монгол Ардын намын хорооны Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянгол сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /.../ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Баянгол сумын Сонгуулийн хороонд


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**БАЯНГОЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ 2020 ОНЫ ОРОН
НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

УРИАЛГА: БАЯНГОЛЧУУДЫН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ.




Иргэн бүр эрүүл, ажилтай, өрх бүр орлоготой байх нь сумын хөгжил дэвшлийн үндэс болно. Үүний төлөө манай МАН-ын бодлого шийдвэр бүрэн чиглэгдэнэ.

Нэг. Нийгмийн хөгжлийн бодлого

- 1.1 Иргэд хүүхдүүддээ эрүүл монгол хүн зорилтын хүрээнд Элэг бүтэн Монгол, эрүүл шүд-эрүүл хүүхэд хөтөлбөрт бүрэн хамруулна.
- 1.2 Хуримтлалтай хүүхэд хөтөлбөрт хамруулах замаар хүүхэд бүрийг хадгаламжтай болгох аяныг зохион байгуулна.
- 1.3 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэд, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан иргэдийг “цахим карт” олголтод хамруулах ажлыг зохион байгуулна.
- 1.4 Цэцэрлэг сургуулийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэхэд дотоод гадаадын сургалтад оролцуулж “Чадварлаг багш” хөтөлбөрт хамруулна.
- 1.5 Залуу гэр бүлийн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцааны хөгжлийг дэмжин “Залуу гэр бүл” хөтөлбөрт хамруулна.
- 1.6 Гэр бүл, хүүхэд залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих холбогдох хууль шийдвэрийг хэрэгжүүлэх тодорхой ажил арга хэмжээг зохион байгуулна.

Хоёр. Засаглалын бодлого

- 2.1 Төрийн үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж иргэдэд хүргэх үйлчилгээг шуурхай болгон хүнд суртлыг арилгана.
- 2.2 Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шуурхай шударга шийдвэрлэж, биелэлтийг байнга хянадаг болгоно.
- 2.3 Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга, шударга байдлыг үндсэн шалгуур болгоно. Төрийн байгууллагуудын ажлыг иргэдээр дүгнүүлдэг болгоно.
- 2.4 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг судалгаа дүгнэлтэд тулгуурлан гарч болзошгүй хэрэг зөрчлөөс сэргийлэн эргүүл-хяналтыг хуулийн байгууллага, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулна.
- 2.5 Орон нутагт архи согтууруулах ундаа борлуулах, түүгээр үйлчлүүлэх цэгийн тоог гарсан шийдвэрийн дагуу тогтоон мөрдүүлж ажиллана.



Гурав. Эдийн засаг, орон нутгийн хөгжлийн бодлого

- 3.1 Улсын чанартай замын дагууд байгаа худалдаа үйлчилгээний цэг салбаруудыг улам өргөжүүлэн тохижуулж, орон нутгийн бүтээгдэхүүнийг байнга борлуулах боломжийг өргөжүүлнэ.
- 3.2 Малын арьс шир, ноос ноолуурыг үндэсний үйлдвэрлэгчдэд нийлүүлж малчдын орлогыг нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах бодлого боловсруулна.
- 3.3 Дулааны төвийн хүчин чадлыг одоогийнхоос нэмэгдүүлж барилга орон сууцны дулаан хангамжийг сайжруулан оршин суугчид, ажиллагчдын ая тухтай байдлыг хангах асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 3.4 Загдалын ногооны талбайн усалгааны асуудлыг мэргэжлийн байгууллагатай хамтран, шийдвэрлэх тал дээр анхаарч ажиллана.
- 3.5 Баян хөгжил сангаас олгох “Итгэлийн зээл”-ийн хүүг бууруулах журмыг боловсруулж ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулж ажиллана.
- 3.6 Төвийн хорооллын гудамжинд камер байрлуулан хэрэг зөрчлөөс сэргийлэх, гаргасан зөрчлийг таслан зогсоох, шийдвэрлэхэд чиглүүлж ажиллана.
- 3.7 Сумын төвд мал нядалгааны газартай болох асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэн, эрүүл ахуйн шаардлага хангасан махаар болох асуудлыг иргэдийг хангана.
- 3.8 Хараа голд гүүр тавих асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж, малчдыг зуслан өвөлжөөндөө буух, өвс тэжээл тээвэрлэхэд хүндрэл бэрхшээлгүй болгоно.
- 3.9 Хадлангийн талбайг бордох, өнжөөж ургацыг нэмэгдүүлэн, тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүд болон тариалах, малчдад газар олгох, замаар өвс тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж ажиллана.
- 3.10 Сүү хүлээн авах, хөргөх цэгийг шаардлагатай газруудад байгуулан, малчид, мах бүхий иргэдийн орлогыг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.
- 3.11 Сумын төвийг ногоон бүс болгох зорилтоор жил бүр мод тарих ажлыг иргэд, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор зохион байгуулна.
- 3.12 Төвийн гэр хорооллын нүхэн жорлонг эко болгох хөдөлгөөн өрнүүлж хөрсний бохирдол, өвчлөлөөс хамгаалах арга хэмжээ авна.
- 3.13 Сумын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулан, орчны бохирдлоос хамгаална.
- 3.14 Малчид тариаланчдыг бэлтгэхдээ “Илгээлтийн эзэн” аянд хамруулна. Мөн МСҮТ-өөр мэргэжил олгож ажлын байраар хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтарч шийдвэрлэнэ.

- 137142093
МОА065 9053436
- 3.15 Атрын 4 аяныг бүтээлчээр хэрэгжүүлж газар тариалан – эрчимжүүлсэн мал аж ахуй хосолсон бус нутгийг хөгжүүлэх бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 3.16 Эрчимжсэн МАА, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд мах, сүүний үхрийг тэжээх жор нормоор тэжээл, тариалж, тэжээлийн үйлдвэр байгуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 3.17 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн байгууллагуудад сумын иргэдийг ажиллуулах замаар ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах бодлого барьж ажиллана.

Дөрөв. ХАРАА БАГТ

- 4.1 Аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран Найрамдал хэсгийн сайжруулсан замыг хатуу хучилттай болгох ажлыг зохион байгуулна.
- 4.2 Багийн иргэдийн зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахаар төмөр замд нүхэн гарц хийх асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 4.3 Багийн өрхүүдийг үерийн уснаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 4.4 Багийн гудамжнуудыг гэрэлтүүлэгтэй болгох ажлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.


Тав. БАЯН БАГТ

- 5.1 Төв хөдөөд шаардлагатай худаг гарган усан хангамжийг сайжруулна.
- 5.2 Багийн 2-р хэсгийн эхний гудамжны өрхүүдийг дулаан цэвэр бохирын шугамд холбох, улмаар багийн нийт өрхүүдийг хамруулах талаар холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 5.3 Иргэдийг хашаандaa тарьсан төмс, хүнсний ногоог услах, ахуйн хэрэглээний усаар хангах усан хангамжийн системийг засварлах ажлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 5.4 Багийн Дээжийн хэсгийн босоо тэнхлэгийн гол замыг хатуу хучилттай болгох асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилж, хамтран шийдвэрлэх ажлыг зохион байгуулна.

Зургаа. ГОНИР БАГТ

- 6.1 221, 212-р зөрлөгийн өрхүүдийн цахилгаан эрчим хүчиний хангамжийг сайжруулах асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 6.2 Төв хөдөөд шаардлагатай худаг гаргаж, усан хангамжийг сайжруулна.
- 6.3 Хорооллын гудамжны гэрэлтүүлгийг хийж гүйцэтгэх ажлыг холбогдох байгууллагад уламжилж, хэрэгжүүлнэ.
- 6.4 Гонирын хэсгийн сайжруулсан замыг хатуу хучилттай болгох асуудлыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй хамтран хэрэгжүүлнэ.

- 6.5 Усан хангамжийн системийг засварлан ажиллуулж өрхийн тариалсан төмс, хүнсний ногоог услах, хэрэглээний усаар хангах асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.



ИРГЭД СОНГОГЧИД ОО

Баянгол сумын МАН орон нутгийн сонгуульд ялалт байгуулснаар иргэд та бүгдийнхээ орлогыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийг сайжруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх арга хэмжээг бүрэн шийдвэрлэж хэрэгжүүлнэ. **ТА БҮГД ИТГЭ-БИД ХЭРЭГЖҮҮЛЬЕ.**

БАЯНГОЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

